

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан	13
4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	13
4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	14
4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	17
4.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн Тайлангийн Аудит
ТХН	Төсөл Хэрэгжүүлэх Нэгж
ТӨҮГ	Төрийн Өмчит Үйлдвэрийн Газар
АХБ	Азийн Хөгжлийн Банк



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

“БАРУУН БҮСИЙН БОСОО ТЭНХЛЭГИЙН
АВТО ЗАМЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ХӨТӨЛБӨР ТӨСӨЛ-2 (МОН-3129)”-ИЙН
ЗОХИЦУУЛАГЧ Б.БАЯН-АМГАЛАН ТАНАА

2020.04.30 № 06/1445
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замын хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл-2 (МОН-3129)”-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замын хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл-2 (МОН-3129)-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал


- Татварын байгууллагад ХХОАТ төлөгчөөр бүртгүүлээгүй, 14,951.3 мянган төгрөгийн ХХОАТ-ыг тайлагнаагүй;
- Санхүүгийн тайлан нь гүйлгээ баланстайгаа тохирохгүй, ерөнхий журналын 2 талт бичилт нийт 68,723.2 мянган төгрөгөөр зөрүүтэй
- зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн үнэн зөв, иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замын хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл-2 (МОН-3129) нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замын хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл-2 (МОН-3129)-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төслийн зохицуулагч Б.Баян-Амгалан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн ажил гүйлгээг стандартын дагуу зөв бүртгэх, харилцагч байгууллагуудаас э-баримтыг авч хэвших, түрээсийн зардлыг бууруулах, шилэн дансны мэдээллийг хугацаанд нь байршуулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замын хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл-2 (МОН-3129)”-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замын хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл-2 (МОН-3129)”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 4 дүгээр сарын 02-ноос 2020 оны 4 дүгээр сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Грант Торнтон аудит” ХХК-ийн туслах аудитор Ц.Баттуяа, туслах аудитор Э.Цэвээндаш нар Үндэсний аудитын газрын захиалгаар хариуцаж хэрэгжүүлэв.

“Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замын хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл-2 (МОН-3129)”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Грант Торнтон аудит” ХХК-д 2020 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр ирүүлсэн.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

“Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замын хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл-2 (МОН-3129)”-ийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь өөрийн орон нутаг дэвсгэрээр олон улсын транзит тээврийг нэвтрүүлэх боломжийг бүрдүүлсэн, манай улсын баруун бүс нутгийн нийгэм, эдийн засаг, дотоодын авто тээврийг эрчимтэй хөгжүүлэх, улмаар хөрш орнуудын дамжин өнгөрөх ачаа, зорчигч тээвэрлэлтийг нэмэгдүүлж, дотоодын худалдаа, зах зээлийг хөгжүүлэн олон улс, бүсийн ач холбогдол бүхий нийгэм, эдийн засгийн үр ашигтай, Азийн замын стандартад нийцсэн, техникийн аюулгүй байдлыг хангасан Ярант-Ховд-Өлгий-Улаанбайшинт чиглэлийн 743.1 км авто зам барих юм.

2019 оны төслийн хэрэгжилтийн хувьд Ховд, Баян-Өлгий аймагт 163.9 км хатуу хучилттай авто зам баригдах дараах багцуудыг гүйцэтгэжээ. Үүнд:

1. CW1-1 Хашаатын даваа-Шургын гүүр чиглэлийн 50 км,
2. CW1-2 Шургын гүүр-Ховд чиглэлийн 53.9 км,
3. CW1-3 Хашаатын даваа-Толбо сум чиглэлийн 60 км

Нийт 163.9 км хатуу хучилттай авто зам барих ажлыг гүйцэтгэж 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдөр тус тус ашиглалтад хүлээлгэн өгсөн байна.

Авто замын барилгын ажлын CW1-1, CW1-3 багцын гүйцэтгэгчээр БНХАУ-ын “China Huanshi Enterprises” компани, CW1-2 багцын гүйцэтгэгчээр “HKV international holding” ХХК ажиллаж, барилгын хяналт, зөвлөхийн үйлчилгээг үзүүлэхээр БНЭУ-ын “Intercontinental Consultant & Technocrats PVT” ХХК болон Шведийн “Sweden National Road Consulting AB, Монгол Улсын “ICT-SAIN Consulting” ХХК-ийн хамтарсан түншлэл ажилласан байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

“Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замын хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл-2 (МОН-3129)”-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Төсөл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Microsoft Excel” программ хангамж ашигладаг байна.

Төслийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар “Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замын хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл-2 (МОН-3129)”-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 12 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, төслийн ихэнх зарцуулалт АХБ-наас гүйцэтгэгчид шилжүүлдэг шууд төлбөрүүд байдаг тул дотооддоо гарч буй зардлуудыг шалгахын тулд материаллаг байдлын түвшний суурь үзүүлэлтийг 0.2 хувиар тооцсон.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 36,441,171.1 мянган төгрөгөөс тооцон 72,882.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг өөрчлөөгүй болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

“Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замын хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл-2 (МОН-3129)”-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 37,435,150.0 мянган төгрөгөөр буюу 21.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	30,798.8	22,012.2	(8,786.6)
Урьдчилж төлсөн зардал	318,045.4	-	(318,045.4)
Нөөцийн бараа	125,109,481.8	162,862,184.0	37,752,702.2
Үндсэн хөрөнгө	-	9,279.8	9,279.8
Нийт хөрөнгө	125,458,326.0	162,893,476.0	37,435,150.0
Өр төлбөр	318,045.4	3,440,967.0	3,122,921.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	125,140,280.6	159,452,509.0	34,312,228.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	125,458,326.0	162,893,476.0	37,435,150.0

Дараах дансад өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Урьдчилж төлсөн зардал дансны дүн буурсан нь 2018 онд зөвлөхийн үйлчилгээний ажлын 215,762.7 мянга, замын ажил гүйцэтгэгчийн 102,282.7 мянга нийт 318,045.4 мянган төгрөгийн урьдчилгаа төлбөрийн ажлын гүйцэтгэлийг 2019 онд хүлээн авснаар нөөцийн бараа дансанд капиталжуулан бүртгэжээ.

Нөөцийн бараа дансанд 2018 онд төлсөн 318,045.4 мянган төгрөгийн урьдчилгааны гүйцэтгэл болон 2019 оны АХБ-ны зээлийн 37,434,656.8 мянган төгрөгийн санхүүжилтээр гүйцэтгэсэн, Зам, тээврийн хөгжлийн яаманд хүлээлгэн өгөх авто замын ажлыг нэмж бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгө 2019 онд худалдан авсан 10,439.7 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, 1,159.9 мянган төгрөгийн элэгдлийн зардлаар буурсан байна.

Өр төлбөрийн дансны өсөлтөд тайлант онд үүссэн АХБ-ны зээлийн санхүүжилтээр төлөх авто замын ажлын гүйцэтгэгчдийн 3,188,745.1 мянган төгрөг, зөвлөх үйлчилгээний 252,221.8 мянган төгрөгийн өглөг нөлөөлсөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 34,312,228.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд хөрөнгө оруулалтын замын ажлын гүйцэтгэлийг АХБ-ны зээлийн хөрөнгөөр санхүүжүүлсэн орлого үр дүнг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

“Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замын хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл-2 (МОН-3129)”-ийг хэрэгжүүлэхэд зориулан 37,036,226.7 мянган төгрөгийн төсөв батлагджээ.

Тайлант онд гүйцэтгэлээр 34,309,499.9 мянган төгрөгийг АХБ-наас, 2,131,696.7 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжиж, 2,444.6 мянган төгрөгийн харилцах дансны хүүгийн орлого бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 36,452,952.7 мянган төгрөг буюу 98.4 хувьтай байна. Хүүгийн орлого 2,444.6 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд 8 чиглэлээр 12 эрсдэл тогтоосон бол гүйцэтгэлийн үе шатанд 4 эрсдэл нэмж илрүүлэн, нийт 16 эрсдэл бүрд горим сорил хэрэгжүүлж гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Аудитаар нийт 65,976,258.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 41,539,973.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 82.1 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 83,957.0 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 24,352,245.5 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгав.

1. Санхүүгийн тайланд дараах залруулгуудыг хийлээ. Үүнд:

- Мөнгөн гүйлгээний тайланд АХБ-наас гүйцэтгэгч рүү шууд шилжүүлсэн, төслийн харилцаагаар дамжаагүй 33,828,611.7 мянган төгрөгийн санхүүжилт, зарцуулалтыг бүртгэсэн нь санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангаагүй;
- Ажлын гүйцэтгэлийг хүлээн авсан боловч төлбөрийг шилжүүлээгүй байгаа 3,188,745.1 мянган төгрөгийн авто замын барилгын гүйцэтгэл, 252,221.8 мянган төгрөгийн зөвлөхийн гүйцэтгэл, нийт 3,440,967.0 мянган төгрөгийн гүйцэтгэлийг урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн нь Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 25-ны 282 тоот тушаалын хавсралт "Төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 16.3 дахь заалттай нийцээгүй;
- МУЗГ-ын санхүүжилтээр худалдан авсан 2,131,696.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг тайлант үеийн зардлаар бүртгэлгүй, бусад эргэлтийн хөрөнгөөр бүртгэсэн нь Сангийн сайдын 2007 оны 326 тоот тушаалаар батлагдсан "Төсөл, тусгай сангуудын санхүүгийн тайланг бэлтгэх заавар"-тай нийцээгүй;
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд 2,131,696.6 мянган төгрөгийн МУЗГ-ын санхүүжилт, зарцуулалтыг тусгаагүй нь санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангаагүй;
- Тусгай дансны үлдэгдлийг тооцоолоход үүссэн 2,995.0 мянган төгрөгийн гадаад валютын ханшийн зөрүүний хэрэгжээгүй олзыг бүртгэхдээ зардлыг бууруулсан нь Сангийн сайдын 2007 оны 326 тоот тушаал "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 2.15 дахь заалттай нийцээгүй;

- Санхүүгийн үр дүнгийн тайланд 2,444.6 мянган төгрөгийн хүүгийн орлого, зардлыг тусгаагүй нь санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангаагүй;
 - 893.4 мянган төгрөгийн ханшийн зөрүүний олзыг бүртгээгүй, 544.8 мянган төгрөгийн ханшийн зөрүүний гарзыг үндэслэлгүй бүртгэсэн;
 - Урьдчилж гарсан зардал болон хувь хүнд төлөх өглөгийг 98.4 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн;
 - АХБ-аас санхүүжүүлсэн, тусгай данс руу шилжүүлсэн санхүүжилтийг 25.4 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн алдааг залрууллаа.
2. Тайлант хугацаанд ажиллагсдын цалинг тооцоолохдоо нийгмийн даатгалын шимтгэлийг буруу тооцоолж 82.1 мянган төгрөгийн цалин илүү олгосон нь Сангийн сайдын 2007 оны 326 тоот тушаалын хавсралт 1-ийн 3.7-д "Нийгмийн даатгалын зардлыг хүлээн зөвшөөрөх болон үнэлж тодорхойлохдоо Нийгмийн даатгалын тухай хууль болон Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль, түүнийг хэрэгжүүлэх заавар журмын холбогдох заалтыг дагаж мөрдөнө. Ажил олгогч нь ажиллагсдад олгох цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын хураамжийг хууль тогтоомжийн дагуу тодорхойлсон хэмжээгээр уг зардлыг хүлээн зөвшөөрч бүртгэнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

3. Санхүүгийн тайлан нь гүйлгээ баланстайгаа тохирохгүй, ерөнхий журналын 2 талт бичилт нь нийт 68,723.2 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь НББ-ын тухай хуулийн "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтөлнө" гэсэн заалттай нийцэхгүй байна. Өмнөх оны аудитаар илэрсэн алдаа давтагдаж байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

4. Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагын дагуу ХХОАТ төлөгчөөр бүртгүүлсэн боловч 14,951.3 мянган төгрөгийн ХХОАТ-ыг тайлагнаагүй, 282.5 мянган төгрөгийн бараа материалыг зардалд шууд бүртгэсэн зөрчлүүд давтагдсан нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1. "... суутгасан албан татварын улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор өссөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд ирүүлнэ.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө." гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

5. ТХН нь 2019 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа ҮАГ-т хуулийн хугацаандаа ирүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1. "...жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, ..." гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

“Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замын хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл-2 (МОН-3129)”-ийн хувьд дараах 2 асуудлуудыг анхаарал татахуйц гэж үзлээ. Үүнд:

- Аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй;

- Төсөл нь 2020 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болгон хаагдаж байгаатай холбогдуулан бусад эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй авто замыг хүлээлгэн өгөх, шилжүүлэх, данс бүртгэлд тусгах асуудал байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замын хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл-2 (МОН-3129) нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус төсөл нь 2019 онд Шилэн дансны тухай хуулийн дагуу төсөв гүйцэтгэлийн 9 мэдээлэл, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын 5 мэдээлэл, бусад 6 мэдээлэл, нийт 20 мэдээлэл байршуулахаас 11 мэдээллийг зарим саруудад хуулийн хугацааг хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 албан шаардлага, 3 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан боловч 1 албан шаардлага, 1 зөвлөмжийн биелэлт хангалтгүй байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замын хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл-2 (МОН-3129)-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хязгаарлалттай” дүгнэлт

Залруулагдаагүй 24,436,284.7 мянган төгрөгийн алдаа зөрчил нь бидний тогтоосон 72,882.3 мянган материаллаг байдлын түвшнээс их байгаа тул хязгаарлалттай дүгнэлт өгч байна.

Төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөөг эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд Менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь “Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замын хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл-2 (МОН-3129)”-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Зардлын данстай холбоотой асуудлууд

3.1.1 Илрүүлэлт

Тайлант хугацааны 39,451,828.1 мянган төгрөгийн худалдан авалтыг НӨАТ-ын хэрэглэгчийн системтэй тулган шалгахад 15,113,569.2 мянган төгрөгийн НӨАТ-с чөлөөлөгдсөн худалдан авалт, 8,013.0 мянган төгрөгийн НӨАТ-с чөлөөлөгдөөгүй худалдан авалт бүртгэгдсэн боловч 24,338,258.9 мянган төгрөгийн худалдан авалт бүртгэгдээгүй, төлбөрийн баримт /э-баримт/-ыг анхан шатны баримтад бүрэн хавсаргаагүй нь харилцагч, бэлтгэн нийлүүлэгч байгууллагууд НӨАТ-ыг санхүүгийн болон татварын тайланд тусгахгүй байх, орлогоо нуун дарагдуулах боломжийг бүрдүүлсэн байна. Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйл 17.6-т "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч байгууллагууд нь борлуулалтын орлого, НӨАТ-ыг санхүүгийн болон татварын тайланд тусгахгүй байх, орлогоо нуун дарагдуулах эрсдэлтэй байна.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйл 17.6 "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй." заалтыг хэрэгжүүлж, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах, НӨАТ-с чөлөөлөгдөөгүй худалдан авалт хийж, төсвийн мөнгийг үр ашиггүй зарцуулахгүй байхыг зөвлөж байна.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Төслийн авто зам барилгын ажил Ховд, Баян-Өлгий аймгийн төв суурин газруудаас алслагдсан газруудад хийгдэж байгаа бөгөөд олон тээврийн хэрэгсэл дамжиж баримт материалууд ирдэг учраас зарим үед хүлээгдэх зэрэг хүндрэл гардаг. Төлбөрийн баримтыг худалдан авагч нараас шаардаж, тухайн үед ирүүлсэн анхан шатны баримтад материалуудыг хавсаргасан.

3.2.1 Илрүүлэлт:

Төслийн нэгж нь 2018 оны 6 дугаар сарын 4-ний өдөр “АРЖ ГРУПП” ХХК-тай 145 м.кв талбайг м.кв нь 38.0 мянган төгрөгөөр түрээслэхээр ОТ/18/18 дугаартай гэрээ байгуулж, тайлант онд нийт 67,070.0 мянган төгрөг төлсөн байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2018 оны №01 дугаартай хуралдааны тэмдэглэлд заасан “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын бусдаас түрээсэлдэг байр талбайн дээд хязгаар 30.0 мянган төгрөгөөс ихгүй байх” заалтыг зөрчиж, тайлант оны түрээсийн зардалд 13,920.0 мянган төгрөг илүү зарцуулсан байна.

3.2.2 Эрсдэл:

Төслийн хөрөнгийг үрэлгэн зарцуулах.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Түрээсэлдэг байр талбайн дээд хязгаар 30.0 мянган төгрөгөөс ихгүй байхаар түрээсийн байр түрээслэх.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.3.1 Илрүүлэлт:

Ажиллагсдын цалинг бодохдоо ХХОАТ-ын хөнгөлөлтийг тооцолгүй 66.6 мянган төгрөгийн цалинг дутуу олгосон нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23.1-д "Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.3.2 Эрсдэл

Цалинг буруу тооцоолсон байх.

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23.1-д "Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ" гэсэн заалтыг мөрдөж ажиллахыг зөвлөж байна.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Дутуу олгосон цалинг нөхөж олгоно.

3.4 Шилэн данстай холбоотой асуудал

3.4.1 Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудсанд 11 мэдээллийг хуулийн хугацаа хоцроож байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-т “Жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор;”, 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

3.4.2 Эрсдэл

Шилэн дансны тухай хууль хэрэгжихгүй байх эрсдэлтэй байна.

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 2 дугаар бүлэг 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасан хугацаанд мэдээллийг байршуулж байх.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь байршуулах талаар цаашид анхаарч ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	125,458,326,122.52	162,884,196,323.85
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	30,798,849.45	22,012,271.17
312	Банканд байгаа бэлэн мөнгө	30,798,849.45	22,012,271.17
3121	Төгрөг	47,418.08	-
31211	Төрийн сангийн харилцах	47,418.08	-
3122	Гадаад валют	30,751,431.37	22,012,271.17
31223	Арилжааны банк дахь харилцах	30,751,431.37	22,012,271.17
34	УРЬДЧИЛГАА	318,045,423.90	-
34600	Урьдчилж гарсан зардал	318,045,423.90	-
36	НӨӨЦИЙН БАРАА	125,109,481,849.17	162,862,184,052.68
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	125,109,481,849.17	162,862,184,052.68
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	-	9,279,770.00
392	Биет хөрөнгө	-	9,279,770.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	-	10,439,740.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	(1,159,970.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	125,458,326,122.52	162,893,476,093.85
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	318,045,423.90	3,440,967,003.49
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	318,045,423.90	3,440,967,003.49
413	Өглөг	318,045,423.90	3,440,967,003.49
4136	Бусад өглөг	318,045,423.90	3,440,967,003.49
41361	Байгууллагад өгөх өглөг	318,045,423.90	3,366,617,993.01
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	74,349,010.48
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	125,140,280,698.62	159,452,509,090.37
51	Засгийн газрын хувь оролцоо	125,140,280,698.62	159,452,509,090.37
512	Хуримтлагдсан үр дүн	125,140,280,698.62	159,452,509,090.37
51210	Өмнөх үеийн үр дүн	50,982,357,345.37	125,140,280,698.62
51220	Тайлант үеийн үр дүн	74,157,923,353.25	34,312,228,391.74
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	125,458,326,122.52	162,893,476,093.85

4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	76,086,664,598.78	36,443,641,254.65
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	74,407,764,598.78	34,311,944,567.15
120	Нийтлэг татварын бус орлого	1,426,044.61	34,311,944,567.15
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,426,044.61	34,311,944,567.15
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,426,044.61	2,444,635.48
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	-	34,309,499,931.67
